



ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын Хөрөнгө гаргах тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/31 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас зарласан Салаа замуудыг хаах ГТБЦГХЗ/202004001 тоот цахим тендерт хамгийн сайн үнэлэгдсэн "Хөх Монгол майнинг" ХХК-иар зам, маршрутаар байгальд ул мөр бага үлдээж аялаж амрах зорилгоор салаа замуудыг хаах ажлыг зохион байгуулан ажиллахыг Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн /Н.Эрдэнэбилэг/-д даалгасугай.

2. Салаа замуудыг хаах ажлын зардал 27.550.000 /Хорин долоон сая таван зуун тавин мянган/ төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын Хөрөнгө гаргах тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/31 дугаар тушаалаар эрх олгосон зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Гандолгор/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлыг зохион байгуулан тайлагнахыг хамгаалалтын захиргааны даргын 2020 оны 05 дугаар сарын 22-ны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, ахлах мэргэжилтэн /С.Бэлэгсайхан/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ДУЛАМСҮРЭН